



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



СУУРЬ БОЛОВСРОЛЫН
ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ
ШАЛГУУРЫГ ХЭРЭГЛЭХ ЗӨВЛӨМЖ

ДҮРСЛЭХ УРЛАГ

УЛААНБААТАР 2021

СУУРЬ БОЛОВСРОЛЫН
ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ
ШАЛГУУРЫГ ХЭРЭГЛЭХ

ЗӨВЛӨМЖ

ДҮРСЛЭХ УРЛАГ

АНХНЫ ХЭВЛЭЛ

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Суралцагчийн үнэлгээ 2

СУУРЬ БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

Нэг. Үнэлгээний шалгуурыг хэрэглэх арга зүйн зөвлөмж..... 5

Хоёр. Нэгжийн үнэлгээний жишиг даалгавар 13

✓ Даалгавар боловсруулах арга зүй, зөвлөмж 13

✓ Нэгжийн үнэлгээний жишиг даалгавар 14

Гурав. Үнэлгээний даалгаварт шинжилгээ хийх, багшлахуйд
дэмжлэг үзүүлэх арга зүй 21

✓ Даалгаварт шинжилгээ хийх аргачлал..... 21

СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭ

Боловсролын үнэлгээний нэг чухал хэсэг нь суралцагчийн үнэлгээ юм. Энэ нь суралцагчийн суралцах үйл ажиллагаа /суралцахуй/-ны талаарх мэдээлэл цуглуулах, сайжруулах, шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах зорилгоор системтэй мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт хийх үйл явц юм. Багш нар хичээл сургалтын явцад суралцагчийг үнэлж журналд дүн тавих, нэгж, бүлэг сэдвийн дараа шалгалт /сорилго¹/ авах, засаж оноожуулах /хэмжилт хийх²/, үнэлж дүгнэх³ зэрэг байнга хийдэг ажил нь үнэлгээний үйл явцад хамаарна.

Бид үнэлгээний шалгалт авах, дүн тавих үйл явцыг хийдэг боловч шалгалтаар дамжуулан суралцахуйн талаар ямар ач холбогдолтой мэдээлэл цуглуулж буй, үр дүнд шинжилгээ хийх, шинжилгээний үр дүнг сургалтын үйл ажиллагаанд бүтээлчээр хэрэглэх байдлыг орхигдуулж ирсэн. Суралцагчийн үнэлгээг зөвхөн дүн тавихын тулд хийж ирсэн тогтсон ойлголт, хандлагыг өөрчлөх хэрэгцээ байна.

Суралцагчийн үнэлгээ гэдэгт “суралцагчийн сурлагын амжилтын түвшнийг тогтоох, мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг бодитой үнэлэх, түүнд тулгарч буй бэрхшээлийг илрүүлж дэмжлэг үзүүлэх, урамшуулах үйл явц”-ыг ойлгоно.

Хичээл, сургалтын өдөр тутмын болон тодорхой хугацааны /бүлэг сэдэв, хагас жил, жилийн эцэс/ дараа хийдэг бүх төрлийн үнэлгээ **“шалгуур”**-т суурилсан байна.

ШАЛГУУРТ СУУРИЛСАН ҮНЭЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР

Багш нарын хувьд **“үнэлгээ”**-г шалгуурт суурилсан байдлаар үр дүнтэй хийхийн тулд үнэлгээний шалгуур болон шалгуурт суурилсан үнэлгээний талаарх мэдлэг ойлголтоо өргөжүүлэн гүнзгийрүүлэх шаардлагатай.

Суралцахуйн үр дүнд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшилд баримжаалж боловсруулсан тодорхой шалгуур (хүрэх үр дүн)-тай харьцуулж суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх үйл явцыг шалгуурт суурилсан үнэлгээ /criterion referenced assessment/ гэдэг. Өөрөөр хэлбэл суралцагчийн гүйцэтгэлийг бусад суралцагчтай бус зөвхөн үнэлгээний шалгууртай харьцуулж үнэлж, дүгнэх үйл явц гэсэн үг.

Үнэлгээний шалгуур нь:

- Суралцахуйн үр дүнд нийцсэн сурагчийн гүйцэтгэлийг хэрхэн тодорхойлохыг зааж өгдөг.
- Сурагч суралцахуйн үр дүнг амжилттай эзэмшсэнийг харуулахын тулд юуг хийж чадаж байгаагийн товч илэрхийлэл
- Суралцахуйн үр дүн бүрийг эзэмшсэн байх тодорхой, хоёрдмол утгагүй нотолгоог бий болгох зорилготой.

¹ Сорилго нь бүх суралцагчдыг тодорхой хугацааны дараа зохион байгуулдаг, асуултын багцаас тогтсон үнэлгээний тодорхой төрөл юм. Сорилго нь тоон болон ямар нэг ангиллын хэмжээсийг ашиглан суралцагчийн нэг ба хэд хэдэн шинж чанарыг хэмжих, илэрхийлэх гэсэн системтэй арга хэрэгсэл юм.

² Хэмжилт нь сорилго, эсвэл үнэлгээний төрлийн үр дүнг тусгай дүрэм (жишээлбэл, зөв хариулыг тоолох, оноо өгөх г.м)-ийн дагуу тоогоор илэрхийлдэг. Ихэнхдээ оноо өгөх /scoring/ гэж тодорхойлдог.

³ Үнэлгээний мэдээллийг хэрэглэн, тогтсон шалгуур үзүүлэлтэд харгалзах чансааг тодорхойлох үйл явц

Өөрөөр хэлбэл, үнэлгээний шалгуур гэдэг нь сургалтын явцад суралцагч бүрийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшил буюу хүрэх үр дүн юм.

Үнэлгээний шалгуур нь дараах ач холбогдолтой. Үүнд:


- Суралцагчийн сурлагын амжилтыг үнэлж, дүгнэх ижил хэмжүүрийг тодорхой, ил тод болгох.
- Үнэлгээг зөв, бодитой хийх боломж бүрдэх.
- Даалгавар боловсруулахад баримжаа болох.
- Тухайн суралцагчийн суралцахуйн давуу, сул тал, тулгамдаж буй бэрхшээлийн талаарх мэдээллийг цуглуулах.
- Суралцахуйн арга зүйг төлөвлөх, хэрэгжүүлэх замаар багшлахуйг сайжруулах боломжийг бүрдүүлэх.
- Суралцагчийг ижил шалгуураар үнэлж, тэдний ахиц амжилт, өөрчлөлтийг хянах боломж олгох.

Үнэлгээний шалгуур нь дараах шаардлагад⁴ нийцсэн байна. Үүнд:


- Боловсролын түвшин, анги, судлагдахуун бүрээр залгамж холбоотой, эрэмбэ ахисан байх
- ЕБС-ийн багш нар шууд авч ашиглах боломжтой байхаар боловсруулсан байх
- Оролцогч бүх тал /суралцагч, багш, эцэг эх, асран хамгаалагч гэх мэт/-д ойлгогдохоор товч тодорхой, оновчтой энгийн үг хэллэгээр бичсэн байх
- Давхцалгүй, нэг нэгнээсээ ялгаатай байх
- Суралцагчдад юу хийхийг тодорхой ойлгуулахуйц үйл /түлхүүр үг/ үгсийг ашигласан байх. Жишээ нь: эмхэтгэх, бий болгох, бүтээх, төлөвлөх, дахин боловсруулах, шинжлэх, дизайн хийх, сонгох, ашиглах, хэрэглэх, үзүүлэх, бэлтгэх, ашиглах, тооцоолох, тайлбарлах, урьдчилан таамаглах, харьцуулах, шүүмжлэх гэх мэт
- Сурагчийн гүйцэтгэл нь ажиглагдахуйц, хэмжигдэхүйц байхаар үг сонгох

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУРЫН БҮТЭЦ

Ерөнхий боловсролын сургуулийн түвшинд хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнд тулгуурлан дараах бүтэцтэйгээр боловсруулсан.



⁴Эх сурвалж: Боловсролын салбарын хөгжил-Боловсролын чанарт нөлөөлж буй сургуулийн хүчин зүйлс” судалгааны эцсийн тайлан, 1.14 дэх бүлэг. Азийн хөгжлийн банкны техник туслалцааны төсөл, 2017 он.



Нэг. Үнэлгээний шалгуурыг хэрэглэх арга зүйн зөвлөмж

Зөвлөмжийн энэхүү хэсэгт хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуур, түүнийг сургалтад хэрэглэх арга зүйг жишээгээр тайлбарлав.

✓ Үнэлгээний шалгуур боловсруулсан арга зүй

Суурь боловсролын Дүрслэх урлаг хичээлийн үнэлгээний шалгуурыг дараах аргачлалын дагуу боловсруулсан.

- Дүрслэх урлагийн сургалтын хөтөлбөрийн агуулга, суралцахуйн зорилтыг задлан шинжлэх, уялдаа холбоог тогтоох
- Агуулгын уялдаа холбоог харгалзан үнэлгээний нэгжийг тодорхойлох
- Үнэлгээний нэгж агуулгын суралцахуйн үр дүнг тодорхойлох
- Суралцахуйн үр дүнгээс суралцахуйн үр дүнгийн шалгуур, шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшинг боловсруулсан.

Зураг 1. Үнэлгээний шалгуур боловсруулсан үе шат



✓ Үнэлгээний нэгж

Сургалтын хөтөлбөрүүдийн суралцахуйн зорилтуудыг багцалсан илэрхийлэл;

Суурь боловсролын Дүрслэх урлагийн хичээлийн үнэлгээний нэгжийг сургалтын хөтөлбөрийн агуулгын тогтолцоо (бүлэг), анги хоорондын залгамж холбоог харгалзан төлөвлөсөн. VI-VIII ангид үнэлгээний нэгж ижил байна.

Сургалтын хөтөлбөрийн агуулга /бүлэг/

Бүлэг 1. Дүрслэх урлагийн хэл
Бүлэг 2. Урлан бүтээх
Бүлэг 3. Соёлын үнэт зүйл



Үнэлгээний нэгж

а. Дүрслэх урлагийн хэл
б. Урлан бүтээхүй
в. Соёлын үнэт зүйл

Үнэлгээний нэгжид хамаарах агуулгыг тодорхойлохдоо өргөн хүрээний чухал мэдлэг, ерөнхий чадвар, хандлагад нийцүүлсэн болно.

(а) “Дүрслэх урлагийн хэл”-ийн тухайд дүрслэх урлагийн бүтээлийг бүтээж буй зохиомжийн хэрэгслүүдийг танин мэдэх, онцлог шинжийг мэдэрч туршилтын бүтээл хийх, дүрслэлийн хэл, нэр томъёог үйл ажиллагаатай холбон ойлгох

(б) “Урлан бүтээхүй”-н тухайд сурагчид дүрслэлийн арга, хэрэгслээр дамжуулан бодит байдлаас хүртэж зурж, дүрслэх өөрийн сэтгэгдэл, уран санаагаа дүрслэн урлах, бүтээх үйлээр илэрхийлэх

(в) “Соёлын үнэт зүйл”-ийн тухайд өөрийн орны болон бусад улс орнуудын урлаг соёлын бүтээл, уран бүтээлчдийн талаар судлах, дүрслэх урлагийн бүтээлээр дамжуулан урлагийн үнэ цэнийг олж харах, амьдрал дахь дүрслэх урлагийн холбоо хамаарлыг ухаарч ойлгох

✓ Суралцахуйн үр дүн

Суралцахуйн тодорхой үе шат (ээлжит болон нэгж хичээл, улирал боловсролын түвшин)-ыг дүүргэсний дараа сурагчийн эзэмших мэдлэг ойлголт, чадварыг тодорхойлсон илэрхийлэл;

Суралцахуйн үр дүнг анги тус бүрийн үнэлгээний нэгжид хамаарах агуулгын хамгийн чухал концепцийн мэдлэг, эзэмших чадварыг багтаан тодорхойлсон. “Дүрслэх урлагийн хэл” үнэлгээний нэгжийн суралцахуйн үр дүнг тодорхойлсон аргачлалыг хүснэгт 1-ээр харуулав.

Хүснэгт 1. Үнэлгээний нэгж агуулгын суралцахуйн үр дүнг тодорхойлсон аргачлал (VI ангийн жишээгээр)

№	Сургалын хөтөлбөрийн агуулга, суралцахуйн зорилт	Үнэлгээний нэгж	Нэгжийн суралцахуйн үр дүн
1	6.1а. Уламжлалт болон улс үндэстний өнгийн бэлгэдлийг харьцуулах 6.1б. Өнгийн дагнаас, зохицол, эрс тэс чанарыг урлагийн бүтээлийн жишээ гарган тайлбарлах 6.1в. Шулуун тахир нуман зураасны онцлогийг танин мэдэж тосон харандаа усан будаг ашиглан зураасны чөлөөт зохиомж хийн турших 6.1г. Юмсын хол, ойр байршил ба биетийн эзлэхүүнийг нэг цэгийн алслалтын аргаар дүрслэн харуулах 6.1д. Биеийн ерөнхий хэмжээ, харьцааг баримжаалан дүрслэх аргаар амьтан зурах	Дүрслэх урлагийн хэл	ДУ6.1.ҮД1. Сурагч зохиомжийн ойлголтоо дүрслэх урлагийн хэлээр (өнгө, шулуун ба тахир, нуман зураас, нэг цэгийн алслалт, хэмжээ харьцаа) дамжуулан илэрхийлэн дүрсэлдэг болно. (6.1а, 6.1б, 6.1в, 6.1г, 6.1д)

Нэгжийн суралцахуйн үр дүнгээс анги хоорондын болон тухайн ангийн агуулгын залгамж холбоо, өргөсөл, гүнзгийрлийг тодорхой харагдана.

Хүснэгт 2. Нэгж агуулгын суралцахуйн үр дүн (VI-VIII ангийн жишээгээр)

VI анги	VII анги	VIII анги
Үнэлгээний нэгж: Дүрслэх урлагийн хэл	Үнэлгээний нэгж: Дүрслэх урлагийн хэл	Үнэлгээний нэгж: Дүрслэх урлагийн хэл
ДУ6.1.ҮД1. Сурагч зохиомжийн ойлголтоо дүрслэх урлагийн хэлээр (өнгө, шулуун ба тахир, нуман зураас, нэг цэгийн алслалт, хэмжээ харьцаа) дамжуулан илэрхийлэн дүрсэлдэг болно.	ДУ 7.1 ҮД1.Сурагч зохиомжийн ойлголтоо дүрслэх урлагийн хэлээр (ахромат, хромат өнгө, харандааны нягт сийрэг зураас, хоёр цэгийн алслалтын болон урвуу алслалт, биетийн хэмжээ, харьцаа) дамжуулан илэрхийлэн дүрсэлдэг болно.	ДУ 8.1 ҮД1. Сурагч зохиомжийн ойлголтоо дүрслэх урлагийн хэлээр дулаан, хүйтэн, ойролцоо өнгийн зохицол, цэг толбо зураасыг хослуулсан, хоёр ба гурван цэгийн алслалт, хүний биеийн ерөнхий хэмжээ, харьцаа) дамжуулан илэрхийлэн дүрсэлдэг болно.

✓ Суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуур

Нэгж агуулгын суралцахуйн үр дүнгээс шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон ба “Дүрслэх урлагийн хэл” үнэлгээний нэгжийн суралцахуйн үр дүнгийн шалгуур боловсруулах аргачлалыг хүснэгт 3-аар харуулав.

Хүснэгт 3. Үнэлгээний нэгж тус бүрээр хүрэх суралцахуйн үр дүнгийн шалгуур (VI ангийн жишээгээр)

Үнэлгээний нэгж 1: Дүрслэх урлагийн хэл

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуур
1	ДУ6.1. ҮД1. Сурагч зохиомжийн ойлголтоо дүрслэх урлагийн хэлээр (өнгө, шулуун ба тахир, нуман зураас, нэг цэгийн алслалт, хэмжээ харьцаа) дамжуулан илэрхийлэн дүрсэлдэг болно (6.1а, 6.1б, 6.1в, 6.1г, 6.1д)	ДУ6.1.ҮД1.Ш1. Өөрийн бүтээлдээ өнгийн бэлгэдлийн утгыг шингээж, илэрхийлэн дүрсэлдэг.
		ДУ6.1.ҮД1.Ш2. Өнгийн дагнаас, зохицол, эрс тэс чанарыг өөрийн бүтээлээр илэрхийлэн дүрсэлдэг.
		ДУ6.1.ҮД1.Ш3. Чөлөөт зохиомж хийхдээ зураасны төрлүүдийн (<i>шулуун, тахир, нуман</i>) онцлогийг тусгаж тосон харандаа болон усан будгаар илэрхийлэн дүрсэлдэг.
		ДУ6.1.ҮД1.Ш4. Биеийн ерөнхий хэмжээ, харьцааг баримжаалах аргаар амьтан зурж дүрсэлдэг.
		ДУ6.1.ҮД1.Ш5. Юмсын хол, ойр байршил ба биетийн эзлэхүүнийг нэг цэгийн алслалтын аргаар дүрсэлдэг.

Дүрслэх урлаг судлагдахууны тухайд VI-VIII анги тус бүрд агуулгын 3 нэгж, нэгжид харгалзах 4 суралцахуйн үр дүнг тодорхойлсон байна. Суралцахуйн үр дүн тус бүрийн үнэлгээний шалгуурыг (VI ангид-12, VII ангид-13, VIII ангид-13 шалгуур) боловсруулсан. Мөн шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн 4 түвшинг тодорхойлсон. Шалгуурын гүйцэтгэлийн түвшин тодорхойлсон аргачлалыг хүснэгт 4-өөр харуулав.

Хүснэгт 4. ДУ6.1.ҮД1.Ш4. шалгуурын гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуур	ГҮЙЦЭТГЭЛИЙН ХҮРЭХ ТҮВШИН			
	I	II	III	IV
ДУ6.1.ҮД1.Ш4. Биеийн ерөнхий хэмжээ, харьцааг баримжаалах аргаар амьтан зурж дүрсэлдэг.	Амьтны биеийн хэсгүүдийн (толгой, их бие, хөл гэх мэт) хэмжээ харьцааг хооронд нь харьцуулан тайлбарладаг.	Амьтны биеийн хэсгүүдийн (толгой, их бие, хөл гэх мэт) хэмжээ харьцааг тоймлон дүрсэлдэг.	Том жижиг амьтдын биеийн хэмжээ харьцааг хооронд нь харьцуулан баримжаалж зурж дүрсэлдэг.	Амьтны биеийн ерөнхий харьцааг баримжаалах аргаар сэдэвт зураг зурж дүрсэлдэг.

Гүйцэтгэлийн түвшинг тодорхойлохдоо танин мэдэхүйн түвшинг харгалзан үзсэн.


- I түвшин Юмс үзэгдлийн гадаад шинж чанараар нэг элементийг таних, нэрлэх, ялгаж байгаа байдал
- II түвшин юмс үзэгдлийн элементүүдийн уялдаа холбоо, утга учрыг ойлгосон байдал энэ тайлбарлах, зураг дүрслэлээр илэрхийлэх зэргээр илэрнэ.
- III түвшин Юмс үзэгдлийг хооронд жишин харьцуулах, задлан шинжлэх үйлийг яаж ямар аргаар хийж буй байдал
- IV түвшин Шинэ санаа, арга эрж хайх, асуудлыг шийдвэрлэх, шинэ зүйл бүтээх, системчлэх нэгтгэх, солих, өөрчлөх, загварчилж буй байдал

Суралцахуйн үр дүнг үнэлэх арга зүй

✓ *Сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүй, үнэлгээ*


Суурь боловсролын Дүрслэх урлагийн сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүй, үнэлгээний холбоо хамаарлыг дараах матрицаар харуулав.

Зураг 2. Дүрслэх урлагийн хичээлийн агуулга, арга зүй, үнэлгээний матриц



Дүрслэх урлагийн хичээлээр сурагчид “Бүтээлч эрэлхийллийн арга барил”-ыг эзэмших ёстой. Энэ арга барилыг сурагчид 1) Мэдрэх, хүлээн авах 2) Бүтээх гүйцэтгэх 3) Ойлгох/ үнэлэх үе шат бүхий үйл ажиллагааны явцад эзэмшинэ.

Зураг 3. Бүтээлч эрэлхийллийн арга барил (БЭАБ), сурагчдын эзэмших чадвар



Бүтээлч эрэлхийллийн арга барил, түүнийг хөгжлийг дараах шалгуураар үнэлэхээр сургалтын хөтөлбөрт тусгасан.

Хүснэгт 5. Бүтээлч эрэлхийллийн арга барил(БЭАБ)-ын үнэлгээний шалгуур

Бүтээлч эрэлхийллийн үе шат	БЭАБ-ын үнэлгээний шалгуур
Мэдрэх хүлээн авах үе шат: Ажиглах, эргэцүүлэн бодох	<ul style="list-style-type: none"> • Сонгосон сэдэв, агуулгын хүрээнд мэдээлэлд сонголт хийж цуглуулсан эсэх • Мэдээлэлд шинжилгээ хийх замаар шинэ санаа гаргасан эсэх • Санаагаа хөгжүүлсэн байдал
Бүтээх, гүйцэтгэх үе шат: Илэрхийлэх	<ul style="list-style-type: none"> • Шинэ санаагаа хэрэгжүүлэхдээ материал, арга техникийн оновчтой сонгож хэрэглэсэн эсэх • Шинэ санаагаа илэрхийлэхдээ зохиомжийн зарчимд тулгуурлан бүтээж гүйцэтгэсэн эсэх
Ойлгох/ үнэлэх үе шат: Бүтээлч эрэл хайгуул хийх	<ul style="list-style-type: none"> • Бүтээлтэй холбоотой хувь хүний төсөөлөл, мэдрэмж, туршлагаа хуваалцаж буй байдал • Дүрслэх урлагийн үнэ цэнэ, өөрсдийн амьдрал дахь холбоо хамаарлын ойлголтоо бүтээлийн жишээгээр тайлбарлаж илэрхийлж буй байдал

Сурагчдын бүтээлч эрэлхийллийн чадварыг үнэлгээний шалгууртай уялдуулан үнэлэх нь тун чухал юм.

✓ **Үнэлгээ түүний төрөл, хэлбэр:**

Үнэлгээний талаарх ойлголтыг олон янзаар тодорхойлсон байдаг. Тухайлбал, “...аливаа зүйлийн мөн чанар, үнэ цэнийг тодорхойлох үйл явц” (OCED), “Үнэлгээ нь хөгжлийн үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнг хянах, системтэйгээр эргэж харах хандлага” (SIDA),... чанарын тухай мэдээлэл цуглуулах, шинжилгээ хийх, тайлагнах үе шатуудыг агуулсан цаашдын бодлого, хэрэгжилтийг тодорхойлох систем бүхий эрэл хайгуул” (World Bank) гэж тодорхойлсон байдаг бол манай боловсролын салбарын үнэлгээний бодлогын баримт бичгүүдэд “Сурагчдын сурах үйл ажиллагааг мэдээлэх, сайжруулах, шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах зорилгоор системтэй мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх үйл явц”-ыг үнэлгээ хэмээнэ гэжээ.

Сургалтын үйл ажиллагаанд үнэлгээг дараах байдлаар авч үзэж байна.

1. Оношлох үнэлгээ (diagnostic assessment)
2. Явцын үнэлгээ (formative assessment)
3. Үр дүнгийн үнэлгээ (summative assessment)

Оношлох үнэлгээ гэдэг нь хичээлийн жилийн эхэнд эсвэл сургалтын үйл ажиллагаа эхлэхээс

өмнө суралцагчийн мэдлэг, чадварын түвшинг тандах зорилготой үйл явц бол явцын үнэлгээ нь суралцахуйг дэмжих, сайжруулах зорилгоор хичээл сургалтын явцад тогтмол хийх үнэлгээг хэлдэг байна. Харин үр дүнгийн үнэлгээ нь тодорхой хугацаанд суралцагчийн олж авсан мэдлэг, чадварын түвшинг хэмжихэд чиглэдэг байна. Оношлох, явцын, үр дүнгийн үнэлгээний ялгааг түлхүүр асуултаар тодруулбал:

Үнэлгээний төрөл	Түлхүүр асуулт
1. Оношлох үнэлгээ	Сурагчид юу хэрэгтэй байна вэ?
2. Явцын үнэлгээ	Сурагчид хэр сайн суралцаж байна вэ?
3. Үр дүнгийн үнэлгээ	Сурагчид хэр сайн сурсан бэ? Ямар түвшинд хүрсэн бэ?


Үнэлгээг янз бүрийн хэлбэрээр зохион байгуулдаг. Оношлох, явцын, үр дүнгийн үнэлгээ хийх түгээмэл хэлбэрүүдийн авч үзье.

Оношлох үнэлгээ	Явцын үнэлгээ	Үр дүнгийн үнэлгээ
Тест/ сорилго Судалгаа Ярилцлага Хэлэлцүүлэг Асуулт, харцулт	Ажиглалт Асуулт, харцулт Ярилцлага Хэлэлцүүлэг Асуулга Рубрик Өөрийн болон найз нөхдийн үнэлгээ	Бүлэг сэдвийн шалгалт Улирлын шалгалт Стандартчилагдсан тест Судалгааны ажил Төсөлт ажил

✓ **Үнэлгээний арга зүй**

Суралцахуйн үр дүн, сурагчдын эзэмших мэдлэг чадварыг үнэлэх арга зүйг бүдүүвчээр үзүүлье.


Зураг 4. Үнэлгээний арга зүй



✓ Оношлох, явцын, үр дүнгийн үнэлгээд үнэлгээний шалгуурыг хэрэглэх арга зүй

Дүрслэх урлагийн сургалтын хөтөлбөрийн агуулгын бүлгийг нэгж агуулга хэмээн үнэлгээний нэгжийг тодорхойлсон. Иймээс бүлэг сэдвийн гараа, явц, үр дүнг тодорхойлох, үнэлэхдээ нэгжийн үнэлгээний шалгуураар үнэлэх бүрэн боломжтой юм. Нэгж агуулгын суралцахуйн үр дүн, үнэлгээний шалгуурыг оношлох, явцын, үр дүнгийн үнэлгээнд хэрэглэх аргачлалыг зураг 5-аар харуулав.

Зураг 5. Нэгж агуулгын үнэлгээний зураглал



А/. Оношлох үнэлгээ: Сурагчид юу мэддэг, чаддаг, юу мэдэхгүй, чадахгүй, ямар ойлголт, төсөөлөл, хандлагатай байна вэ? гэдгийг илрүүлэх зорилгоор хичээлийн жил, хагас жил, улирал, бүлэг сэдэв эхлэхийн өмнө оношлох үнэлгээ хийдэг. Оношлох үнэлгээ хийснээр тухайн анги, сурагчийн ялгаатай байдлыг харгалзан агуулгыг бататгах арга зүйг оновчтой төлөвлөн хэрэгжүүлэх суурь мэдээлэлтэй болно. Оношлох үнэлгээний үр дүнг сурагчийн сурлагын амжилт, ахиц, өөрчлөлтийг тооцоход хэрэглэнэ. Оношилгоог тест/ сорилго, судалгаа, ярилцлага гэх мэт янз бүрийн хэлбэрээр хийж болно. Үнэлгээний шалгуур, гүйцэтгэлийн түвшинд нийцүүлэн тест боловсруулж оношилгоог хийж болно. Тестийн даалгавар боловсруулах аргачлалыг жишээгээр харуулав.

Жишээ 1.

Үнэлгээний шалгуур: ДУ 8.3. Ш1.Монголын дүрслэх урлагийн төлөөлөгчдийн бүтээлийг уран зураг унших аргаар таньж тодорхойлдог. (1921 оноос өнөөг хүртэлх)

Гүйцэтгэлийн I түвшин: Тухайн цаг үеийн дүрслэх урлагийн гол төлөөлөгчдийн бүтээлийг таньж нэрлэдэг.

Даалгавар: Дараах уран бүтээлчдийн зурсан зургийг зөв олж харгалзууна уу.

	Зураачид		Уран бүтээлийн нэр	Хариулт
1	Ардын зураач, төрийн шагналт Үржингийн Ядамсүрэн /1905-1986/	А	“АЖЛЫН ДАРАА” 1952 он, зотон, тос 160x200 см	---
2	Ардын зураач, хөдөлмөрийн баатар Ням-Осорын Цүлтэм /1923-2001 он/	Б	“АЗАРГАНЫ НОЦОЛДООН” 1958 он, зотон, тос 147x200см	---
3	Ардын зураач, төрийн шагналт Гэлэгийн Одон /1925-1996 он/	В	“ТАЛЫН АЙЛ” 1955 он, зотон, тос 77x159 см	---
4	Ардын зураач, төрийн хошой шагналт Очирын Цэвэгжав /1915-1975 он/	Г	“ӨВГӨН ХУУРЧ” 1958 он, цаас, гуаш 80x60 см	---

Б/. Явцын үнэлгээ: Явцын үнэлгээний талаар олон эрдэмтэн мэргэд судалсны дотор судлаач Бронвен Кови, Беверли Белл нар “Явцын үнэлгээ бол сургалтын явцад суралцагчийн сурах үйл ажиллагааг таньж мэдэх, сайжруулах, хариу үйлдэл үзүүлэх багш болон суралцагчдын үйл явц юм” гэж тодорхойлсон нь суралцахуй, багшлахуйг дэмжсэн, сурагчдын сурлагын амжилтыг дээшлүүлэх маш үр дүнтэй арга гэдгийг илтгэж байна. Суралцахуй үйл ажиллагааны явцад үнэлгээний шалгуурт тохирох өөрийн үнэлгээний хуудас боловсруулж сурагчдыг үнэлж болно.

Өөрийн үнэлгээний жишээ:

Үнэлгээний шалгуур: ДУ6.2.ҮД2.Ш6. Үсгийн хэлбэрийг уран сайхнаар өөрчлөн, дүрсэлж илэрхийлдэг.

Хүснэгт 5. Өөрийн үнэлгээний хуудас (VI анги)

	Асуулт	Итгэлтэй	Дунд зэрэг	Итгэлгүй
I	Энгийн болон уран сайхны үсгийг ялган таньдаг.	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
II	Үсгийн хэлбэрийг уран сайхнаар өөрчлөн дүрсэлж чадна.	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
III	Үгийг уран сайхнаар дүрсэлж чадна.	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
IV	Үгийн утга санаатай уялдуулан зохиомжлон дүрсэлж чадна.	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Багш, сурагчдын өөрийн үнэлгээний үр дүнд анализ хийж, тэд чухам аль шалгуур дээр хангалтгүй байгааг илрүүлж, цаашид анхаарч арга зүй, төлөвлөлтдөө тусгаж ажиллах хэрэгтэй.

Рубрикээр үнэлэх жишээ: Рубрикийн шалгуур, үзүүлэлт нь ойлгомжтой, энгийн үг хэллэгтэй, оноо нь үгээр илэрхийлэгдсэн байна.

Рубрик боловсруулахдаа:

- Даалгаврын зорилгыг тодорхойлох (юуг үнэлэх вэ?)
- Шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох (яаж үнэлэх вэ?)
- Гүйцэтгэлийг түвшинчилэх (бага ангид үгээр илэрхийлсэн, дунд, ахлах ангид 4 түвшинтэй байвал сайн)
- Түвшин хоорондын ялгааг тодорхойлох

Үнэлгээний шалгуур: ДУ7.2.ҮД2.Ш5 Геометр биетийн гэрэл, сүүдрийг зурааслах аргаар дүрсэлж илэрхийлдэг.

Хүснэгт 6. Рубрикээр үнэлэх хувилбар (VII анги)


Үнэлгээний шалгуур	Бодох хэрэгтэй	Боломж байна	Чадварлаг	Үлгэр жишээ
	1	3	5	7
Геометр биетийн гэрэл, сүүдрийг зурааслах аргаар дүрсэлсэн байдал	Геометр биетийн ерөнхий овор хэмжээг тогтоож ерөнхийлөн байгуулж чадсан бол	Геометр биетийн гэрэл сүүдрийн бүсийг тодорхойлж тэмдэглэсэн бол	Геометр биетийн гэрэл, сүүдрийг зурааслах аргаар ерөнхийлөн дүрсэлж чадсан бол	Геометр биет тус бүрийн гэрэл сүүдэр, хэлбэрийг зурааслах аргаар нарийвчлан дүрсэлж чадсан бол

В/. Үр дүнгийн үнэлгээ: Дүрслэх урлагийн сургалтын хөтөлбөрийн бүлгээр үнэлгээний нэгжийг тодорхойлсон болохыг дээр дурдсан билээ. Иймд бүлэг сэдвийн үр дүнг үнэлгээний нэгжийн суралцахуйн үр дүн, шалгуураар үнэлэх боломжтой. Нэгж агуулгын хүрэх үр дүн, үнэлгээний шалгуурт тохирох цогц даалгаврыг боловсруулж сурагчдын мэдлэг, чадварыг үнэлж болно. Мөн дүрслэх урлагийн хичээлийн тодорхой агуулга, сэдвийн хүрээнд төсөлт ажил хийлгэх замаар сурагчдын эзэмших мэдлэг, чадварыг уг үнэлгээний шалгуураар үнэлнэ. Төсөлт ажлын явц, үр дүнг үнэлэхдээ сурагчдын агуулгаар эзэмших мэдлэг, чадвараас гадна сурагчдын бүтээл эрэлхийллийн арга барил (чадвар)-ыг орхигдуулахгүйгээр үнэлэх нь ач холбогдолтой.

Хоёр. Нэгжийн үнэлгээний жишиг даалгавар

✓ Даалгавар боловсруулах арга зүй, зөвлөмж

Зураг 5. Даалгавар боловсруулах аргачлал



✓ Блюпринт боловсруулах аргачлал

Блюпринт нь даалгавар боловсруулах нарийвчилсан зураглал (матриц) юм. Өөрөөр хэлбэл, даалгаврын агуулга, дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан төлөвлөлт гэж ойлгож болно. Сурагчдаас тодорхой хугацаанд тодорхой агуулгыг багтаасан сэдвийн үр дүнг илрүүлэх шалгалтын даалгавар зохиоход блюпринтийг боловсруулна. Блюпринтийг чанартай боловсруулах нь маш чухал юм. Блюпринтийг боловсруулахад таксономийн мэдлэг шаардлагатай. Одоогоор Блумын таксономи (1956), Соло таксономи (1982)-ийг боловсролын зорилт, үнэлгээг тодорхойлоход түгээмэл хэрэглэж байгаа ба энэ талаарх судалгааны үр дүн багагүй байдаг. Иймээс багш нар таксономийн мэдлэг ойлголтоо нэмэгдүүлэх шаардлагатай юм. Үнэлгээний нэгж, нэгжийн суралцахуйн үр дүнг илрүүлэх шалгалтын агуулга боловсруулахад блюпринтийн дараах загварыг ашиглаж болох юм.

Хүснэгт 7. Блюпринт боловсруулах загвар

№	Үнэлгээний зорилт		Үнэлгээний шалгуур	Гүйцэтгэлийн түвшин	Даалгавар		Танин мэдэхүйн түвшин			
	Мэдлэг ойголт	Чадвар			Сонгох	Задгай	Сэргээн санах, ойлгох	Хэрэглэх	Задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх	Үнэлэх, бүтээх
1										

Дараах нэгж агуулга, үнэлгээний шалгуурт нийцсэн даалгаврын бюпринт боловсруулсан жишээг авч үзье.

✓ **Нэгжийн үнэлгээний жишиг даалгавар**

Үнэлгээний нэгж 3. Соёлын үнэт зүйлс (VIII ангийн жишээгээр)

Суралцахуйн үр дүн: ДУ8.3.УД4. Сурагч Монголын болон сэргэн мандалтын үеийн дүрслэх урлагийн төлөөлөгчдийн бүтээл, чиг хандлага, арга ажиллагааг зарим бүтээлийн жишээн дээр уран зураг унших аргаар таньж тодорхойлдог болно.

Суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуур:

- ДУ 8.3. Ш1. Монголын дүрслэх урлагийн төлөөлөгчдийн бүтээлийг уран зураг унших аргаар таньж тодорхойлдог.
- ДУ 8.3. Ш2. Сэргэн мандалтын үеийн дүрслэх урлагийн зарим бүтээлийг уран зураг унших аргаар таньж тодорхойлдог.
- ДУ 8.3. Ш3. Дүрслэх урлагийн зарим чиг хандлагуудыг бүтээлийн жишээгээр тайлбарладаг.

Хүснэгт 8. Бюпринт боловсруулсан жишээ

№	Үнэлгээний зорилт		Үнэлгээний шалгуур	Гүйцэтгэлийн түвшин	Даалгавар		Танин мэдэхүйн түвшин			
	Мэдлэг ойголт	Чадвар			Сонгох	Задгай	Сэргээн санах, ойлгох	Хэрэглэх	Задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх	Үнэлэх, бүтээх
1	40%	60%	ДУ 8.3. Ш1.Монголын дүрслэх урлагийн төлөөлөгчдийн бүтээлийг уран зураг унших аргаар таньж тодорхойлдог.	I	1		1			
				II		1		1		
				III		1		1		
				IV		1			1	
2	40%	60%	ДУ 8.3. Ш2.Сэргэн мандалтын үеийн дүрслэх урлагийн зарим бүтээлийг уран зураг унших аргаар таньж тодорхойлдог.	I	1		1			
				II		1		1		
				III		1		1		
				IV		1				

Даалгавар боловсруулахд тавигдах ерөнхий шаардлага:

- Даалгаврын тоо гүйцэтгэх хугацааг сурагчдын нас биеийн онцлогт тохируулан оновчтой тогтоох
- Танин мэдэхүйн үе шат, шалгуурт нийцүүлэн даалгаврыг боловсруулах
- Даалгаврыг олон хэлбэрийг ашиглах
- Даалгаврын тохирц, найдвартай байх чанарыг хангах
- Сургалтын хөтөлбөрийн агуулгад үндэслэсэн, сурлагын амжилтыг илрүүлэхүйц байх
- Даалгаврын хариулт (түлхүү)-ийг хамт боловсруулах
- Даалгаврын агуулга салаа утгагүй байх
- Даалгаврыг үнэлгээний шалгуур, гүйцэтгэлийн түвшинд тулгуурлан боловсруулсан байх

✓ **Даалгавар боловсруулах аргачлал**

Үнэлгээний зорилго, зорилтоос хамаарч даалгаврын төрөл хэлбэр харилцан адилгүй байдаг. Тэгэхдээ сонгох болон задгай даалгаврыг төрлийг даалгавар боловсруулахад түгээмэл хэрэглэдэг.

Сонгох даалгавар гэж хариултын хувилбаруудтай түүнээс зөв хариултыг сонгох хэлбэрээр боловсруулсан даалгаврыг хэлнэ. Хариултын хувилбар нь гурваас багагүй таваас ихгүй байх зохимжтой. Хариултын хувилбараас зөв хариулт зөвхөн нэг байна. Харин хариултын бусад хувилбар шалгуулагчид үнэмшил төрөхгүйц байх хэдий ч, зайлшгүй буруу хариулт байна.

Задгай даалгавар нь танин мэдэхүйн дээд түвшний ур чадварыг үнэлэхэд чиглэсэн нээлтэй дэлгэрэнгүй хариултыг шаарддаг байна. Задгай хэлбэрийн даалгавар нь алхамчилсан бүтэцтэй байх бөгөөд хөнгөнөөс хүнд рүү чиглэсэн алхам бүр өөр өөр мэдлэг, чадварыг илрүүлэхээр боловсруулагдсан байхаас гадна алхмууд нь хоорондоо хамааралтай цогц даалгавар байж болно. Цогц даалгавар нь дангаараа нэг бүлэг сэдвийн агуулгыг үнэлэхээс гадна хэд хэдэн агуулгын хүрээг хамарсан байхаар боловсруулагдсан байж болно. Задгай даалгаврыг боловсруулахад даалгаврын зорилго, шалгуур нь тодорхой байх ёстой. Задгай даалгаврыг нөхөх, богино буюу товч хариулттай, дэлгэрэнгүй хариулттай гэсэн гурван төрөлд хуваадаг байна. Дүрслэх урлагийн хичээл нь гүйцэтгэлд тулгуурлан зохион байгуулагдах онцлогтой. Үүнтэй холбоотойгоор шалгалтын агуулга дахь даалгаврууд нь ихэнхдээ задгай хэлбэрээр боловсруулсан байдаг. Үнэлгээний шалгуурт нийцүүлэн боловсруулсан цогц даалгаврын жишээг авч үзье.

Даалгавар жишээ 1.

Үнэлгээний шалгуур: ДУ 8.3. Ш1. Монголын дүрслэх урлагийн төлөөлөгчдийн бүтээлийг уран зураг унших аргаар таньж тодорхойлдог.

I түвшин: Тухайн цаг үеийн дүрслэх урлагийн гол төлөөлөгчдийн бүтээлийг таньж нэрлэн тодорхойлдог.

Даалгавар 1. /Сонгох даалгавар/ Дараах зургаас Ардын зураач, төрийн шагналт О. Цэвэгжавын уран бүтээлийг сонгон дугуйлна уу.



А. “Ажлын дараа”
1952 он



Б. “Азарганы ноцолдоон” 1958 он



В. “Талын айл”
1955 он



Г. “Өвгөн хуурч”
1958 он

(1 оноо)

II түвшин: Бүтээлийн гол ба туслах дүрээр дамжуулан агуулга, уран дүрслэл, онцлогийг тодорхойлдог.

Даалгавар 2. /Задгай даалгавар/

Монголын үнэт уран зургийн бүтээл нэг “Азарганы ноцолдоон” зургийн гол ба туслах дүрийг тодорхойлж, дүрийн онцлогийг тайлбарлан бичээрэй.



Зургийн гол дүр _____

Дүрийн онцлог _____

Зургийн туслах дүрүүд _____

Дүрийн онцлог _____

(4 оноо)

III түвшин: 1921 оноос өнөөг хүртэлх үеийн Монголын дүрслэх урлагийн гол төлөөлөгчид, тэдгээрийн уран бүтээлийг тухайн цаг үеийн түүхэн эх сурвалжтай холбож, тайлбарлан тодорхойлдог.

Даалгавар 3. Монголын дүрслэх урлагийн гол төлөөлөгчдийн дараах бүтээлүүдийн талаар өгөгдсөн асуултын дагуу тайлбарлан бичээрэй.



Зураг 1.



Зураг 2.



Зураг 3.

	Асуулт даалгавар:	Зураг 1.	Зураг 2.	Зураг 3.
1	Уран зургийн нэр:			
2	Уран бүтээлчийн нэр:			
3	Уран бүтээл бүтээгдсэн он:			
4	Уран бүтээлийн зохиомжийн төвийн дүрслэлийг тодорхойлж бичнэ үү.			
5	Уран бүтээлчийн амьдрал, уг бүтээлтэй холбоотой тус бүр 1 сонирхолтой баримтыг бичнэ үү.			

IV түвшин: Монголын дүрслэх урлагийн төлөөлөгчдийн зарим бүтээлийг уран зураг унших аргаар таньж тодорхойлдог. /1921 оноос өнөөг хүртэлх үе/



Уран зургийн нэр: _____

Уран бүтээлчийн нэр: _____

Уран бүтээл бүтээгдсэн он: _____

Уран зургийн хэмжээ : _____

Уран зургийн хэв маяг, ангилал: _____

Энэ зураг хэр үнэ цэнэтэй вэ? _____

Зураач уран бүтээлдээ ямар өнгийг ашигласан байна вэ?

Уран зургийн дүрслэлийг тоочин нэрлэнэ үү.

Уран зургийн зохиомжийн онцлогийн тайлбарлана уу?

Уран зургийн үйл явдал, утга санааг тайлбарлана уу.

Уран зураг танд ямар сэтгэгдэл төрүүлсэн бэ? Яагаад?

Зургийг 3 үгээр илэрхийл. (түлхүүр үг)

✓ **Даалгаврын хариултын хувилбар боловсруулах аргачлал**

Сонгох болон задгай даалгаврыг дүгнэхэд сурагчдын гүйцэтгэсэн үйлдэл бүрд оноо өгөх зарчимд тулгуурласан хариултын хувилбар, оноожуулалт зайлшгүй шаардлагатай. Ялангуяа задгай хэлбэрийн даалгаврын алхам бүрийн хариултын хувилбарыг урьдчилан боловсруулсан байх шаардлагатай. Энэ нь сурагчдын ялгаатай байдлыг илрүүлэх, өөрөөр хэлбэл, сурагчдын тухайн агуулга эзэмшсэн хувийг тодорхойлох боломжийг олгодог. Хариултын хувилбарыг дараах загвараар боловсруулна.

Хүснэгт 9. Хариултын хувилбар боловсруулах загвар

Даалгаврын дугаар	Хариултын хувилбар	Тайлбар	Код	Оноо
	1			
	2			
	3			
	4	Дээрхээс бусад		
	5	Огт хариулаагүй		

Дээрх даалгаврын хариултын хувилбар боловсруулсан жишиг загварыг авч үзье.

Хүснэгт 10. Хариултын хувилбар боловсруулсан жишээ

Даалгаврын дугаар	Хариултын хувилбар	Хариултын тайлбар	Оноо	
Д-1.	А. “Ажлын дараа” 1952 он	-	1	оноо
	Б. “Азарганы ноцолдоон” 1958 он	Зөв хариулт (1 оноо)		
	В. “Талын айл” 1955 он	-		
	Г. “Өвгөн хуурч” 1958 он	-		
	Огт хариулаагүй	-		
Д-2.	Зургийн гол дүрийг нэрлэсэн.	Ноцолдож буй 2 азарга (1 оноо)	4	оноо
	Зургийн гол дүрийн онцлогийг тайлбарласан.	Эрч, хүч сүрлэг байдал (Сүрлэг бадрангуй) (1 оноо)		
	Зургийн туслах дүрийг нэрлэсэн.	Тал нутаг, адуун сүрэг, адуучин залуу (1 оноо)		
	Зургийн туслах дүрийг тайлбарласан.	Ноцолдож буй 2 азарганы сүр хүчийг тодотгож буй цочиж ухасхийх адуун сүрэг, цаанаас 2 азарганы зүг морьтой ухасхийх уураг барьсан адуучин залуу (1 оноо)		
Д-3.	Уран зургийн нэрийг зөв нэрлэсэн.	Зураг 1. Талын айл (1 оноо) Зураг 2. Ажлын дараа (1 оноо) Зураг 3. Өвгөн хуурч (1 оноо)	3	14 оноо
	Уран бүтээлчдийг нэрийг зөв нэрлэсэн.	Зураг 1. Н. Цүлтэм (1 оноо) Зураг 2. Г.Одон (1 оноо) Зураг 3. Ү. Ядамсүрэн (1 оноо)	3	
	Уран бүтээлийн бүтээгдсэн он зөв бичсэн.	Зураг 1. 1955 он, зотон, тос (1 оноо) Зураг 2. 1952 он, зотон, тос (1 оноо) Зураг 3. 1958 он цаас, гуаш (1 оноо)	3	

	Зохиомжийн төв хэсгийн тодорхойлж бичсэн.	Зураг 1. Тэмээ, монгол гэр (1 оноо) Зураг 2. Гаанс барьсан өвгөн (1 оноо) Зураг 3. Хуур тоглож буй өвгөн (1 оноо)	3	
	Уран бүтээлчийн амьдрал, уг бүтээлтэй холбоотой тус бүр 1 сонирхолтой баримт бичсэн.	Баримт 1. (1 оноо) Баримт 2. (1 оноо)	2	
Д-4.	Уран зургийн нэрийг нэрлэсэн.	Азарганы ноцолдоон (1 оноо)	14 ОНОО	
	Уран бүтээлчийг нэрлэсэн.	О. Цэвэгжав (1 оноо)		
	Уран бүтээлийн бүтээгдсэн он бичсэн.	1958 он (1 оноо)		
	Уран зургийн хэмжээг тодорхойлж бичсэн.	Зотон, тос 147x200см (1 оноо)		
	Уран зургийн хэв маяг тодорхойлж бичсэн.	Монголын реалист уран зураг (1 оноо)		
	Уран зургийн үнэ цэнийг тодорхойлж бичсэн.	Монголын түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл (1 оноо)		
	Уран зурагт ашигласан өнгийг тодорхойлж бичсэн.	Хар, шаргал өнгийн эсрэгцүүлж дүрсэлсэн нь хөдөлгөөний эрч, хүч, сүрлэг байдлыг нэмэгдүүлсэн. (1 оноо)		
	Уран зургийн зохиомжийн онцлогийг тайлбарласан.	2 азаргыг зөв гурвалжин хэлбэрт оноон, зохиомжийн төвөөс үл ялиг зүүн тийш, адууны хөдөлгөөнийг ташуу чиглэлд авч дүрсэлсэн нь эрч хүч, сүрлэг байдлыг илтгэсэн, зургийн баруун талд адуучин залуу, цаана адуу сүрэг зэргийг сүлэлдүүлэн тэнцвэржүүлж дүрсэлсэн байна. (1 оноо)		
	Уран зургийн үйл явдал, гол утга санааг тайлбарласан. 1. Дүрс дүрсэлийн тоочин тайлбарласан бол (1 оноо) 2. Дүр, дүрслэл зургийн үйл явдал, илэрхийллийг хобон тайлбарласан бол(2 оноо)	Цэлмэг тэнгэр, тал нутаг, шингэж буй нар, адуун сүрэг, адуучин залуу, ноцолдож буй 2 азарга дүрслэгдсэн. Хөдөөгийн тал нутаг, монгол ахуй, амьдралыг харуулсан эрч хүч, сүрлэг бадрангуй байдлаар илэрхийлсэн. (2 оноо)		
Уран зургаас төрсөн сэтгэгдлээ илэрхийлж бичсэн. 1. Зургаас төрсөн сэтгэгдлээ өөрийн бодлоор илэрхийлж бичсэн бол (1 оноо) 2. Зургаас төрсөн сэтгэгдлээ баримт нотолгоонд тулгуурлан бичсэн бол (2 оноо)		2		
Уран зургийг 3 түлхүүр үгээр илэрхийлсэн.		2		

Даалгаврын жишээ 2.

Үнэлгээний шалгуур: ДУ 8.3.1.Ш12. Сэргэн мандалтын үеийн дүрслэх урлагийн зарим бүтээлийг уран зураг унших аргаар таньж тодорхойлдог.

I түвшин: Сэргэн мандалтын үеийн дүрслэх урлагийн зарим бүтээлийг таньж нэрлэн тодорхойлдог.

Даалгавар 1. Сэргэн мандалтын үеийн уран бүтээлчдийн бүтээлүүдийг олж харгалзуулан бичнэ үү.

	Уран бүтээлчид		Уран бүтээлийн нэр	Хариулт
1	Микеланжело /1475-1564 он/	А	“Сүүлчийн зоог” 460x880см	-----
2	Рафаэль (Raffaello Sanzio da Urbino) /1483-1520/	Б	“Сикстиний сүмийн ханан дахь зураг”	-----
3	Леонарда Да Винчи /1452-1519 он/	В	“Афины сургууль” 500x770см	-----



А



Б



В

II түвшин: Сэргэн мандалтын үеийн зарим дүрслэх урлагийн бүтээлийн онцлогийг тодорхойлдог.

Даалгавар 2. Сэргэн мандалтын үеийн бүтээлүүдийн онцлогийг дараах бүтээлийн жишээн дээр тайлбарлан бичнэ үү.



Уран зургийн нэр: _____

Уран бүтээлчийн нэр: _____

Сэргэн мандалтын үеийн бүтээлийн онцлог: _____

III түвшин: Сэргэн мандалтын үеийн дүрслэх урлагийн бүтээлийн агуулга, утга санааг тухайн цаг үеийн түүхэн эх сурвалжтай холбож, тайлбарлан тодорхойлдог.



Даалгавар 3. Сэргэн мандалтын үеийн бүтээлүүдийн онцлогийг дараах бүтээлийн жишээн дээр тайлбарлан бичнэ үү.

Уран зургийн нэр: _____

Уран бүтээлчийн нэр: _____

Сэргэн мандалтын үеийн уг бүтээлийн агуулга, утга санааг тухайн цаг үеийн түүхэн эх сурвалжтай холбож тайлбарлана уу

IV түвшин: Сэргэн мандалтын үеийн дүрслэх урлагийн зарим бүтээлийг уран зураг унших аргаар таньж тодорхойлдог.

Даалгавар 4.



Уран зургийн нэр: _____

Уран бүтээлчийн нэр: _____

Уран бүтээл бүтээгдсэн үе: _____

Уран зургийн хэв маяг, ангилал: _____

Уран зургийн үнэ цэнэ _____

Уран зургийн өнгө: _____

Уран зургийн дүр, дүрслэл /гол ба туслах дүр/ _____

Уран зургийн зохиомжийн онцлог: _____

Уран зургийн үйл явдал, утга санаа: _____

Уран зураг танд ямар сэтгэгдэл төрүүлсэн бэ? Яагаад?

Зургийг 3 үгээр илэрхийл. (түлхүүр үг)

Гурав. Үнэлгээний даалгаварт шинжилгээ хийх, багшлахуйд дэмжлэг үзүүлэх арга зүй

✓ Даалгаварт шинжилгээ хийх аргачлал

Сургалтын хөтөлбөрийн хүрээнд сурагчдын эзэмших мэдлэг, чадварыг үнэлэх, хэмжээсжүүлэхэд чиглэсэн даалгавар бүхий шалгалтын материалыг боловсруулдаг. Сурагчдын мэдлэг чадварыг хэр бодитой үнэлэх нь тухайн шалгалтын материал дахь даалгаврын чанараас шууд хамаарна. Даалгаврын чанарыг тогтоох, сайжруулах зорилгоор даалгаварт шинжилгээ хийдэг. Мөн сурагчдын даалгаврын гүйцэтгэлд шинжилгээ хийх замаар сурагчдын дутуу болон буруу ташаа ойлголтыг илрүүлэх, бататгах агуулга, арга зүй тодорхойлох, багшлахуй болон хичээлийн арга зүйн санаа боловсруулах зэрэгт ихээхэн ач холбогдолтой.

Даалгаварт шинжилгээ хийх, үр дүнг ашиглах аргачлал:

- Даалгаврын өгөгдөл цуглуулах, үр дүнг нэгтгэх
- Буруу хариулт, алдааны шалтгааныг шинжлэх, оношлох
- Шийдвэрлэх арга замыг дэвшүүлэх, төлөвлөх
- Хичээлийн арга зүй санаа төлөвлөх, хэрэгжүүлэх

✓ Даалгаврын үр дүнг нэгтгэх

Сурагчдын даалгаврын гүйцэтгэлийг дараах өгөгдсөн загвараар нэгтгэж болно.

Хүснэгт. Сурагчдын гүйцэтгэлийг нэгтгэх загвар

	Даалгавар				Авсан оноо	Гүйцэтгэл (хувиар)	Тайлбар
	1	2	3	4			
Сурагч 1							
Сурагч 2							
Сурагч 3							
Авах оноо							
Авсан оноо							
Гүйцэтгэл (хувь)							

✓ **Даалгаврын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх, үр дүнг гаргах**

Үнэлгээ (шалгалт)-ний агуулгад хүнд, дундаж, хөнгөн даалгаврын хувь хэмжээг тохируулахаас тухайн үнэлгээний үр дүн ямар тархалтай байх нь хамаардаг. Үр дүн нь хэвийн (нормаль) тархалттай байх нь сурагчдыг бодитой үнэлэхэд ач холбогдолтой. Мөн даалгаврыг гүйцэтгэх хугацааг бодитой тогтоох чухал байдаг. Даалгаврын хүнд хөнгөний зэрэг болон ялгах чадварын талаарх ойлголт, тооцох арга аргачлалыг судалж өөрсдийн боловсруулсан даалгаврын нийцлийг туршиж сайжруулах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, сурагчдын гүйцэтгэлд тулгуурлан даалгаврын ялгах чадвар (маш сайн, сайн, дундаж, бага, сөрөг) болон хүнд хөнгөний зэргийг (хэт хөнгөн, хөнгөн, дундаж, хүнд, хэт хүнд) тогтоох, харилцан хамаарлыг шинжлэх замаар даалгаврыг сайжруулах чиглэлийг тодорхойлно. Ингэж сайжруулсан даалгавар нь сурагчдын мэдлэг, чадварыг бодитой үнэлэх, даалгаврын сайн сан бүрдүүлэхэд ач холбогдолтой. Үүнээс гадна сурагчдын даалгаврын гүйцэтгэлийн үр дүнгээс агуулгын хэрэгжилтийн талаарх чанарын мэдээллийг цуглуулж багшлахуйг сайжруулах, үр дүнд тулгуурласан хичээлийн арга зүйн санаа боловсруулж хэрэгжүүлэх бүрэн боломжтой юм.


Үнэлгээний үр дүнд тулгуурлан хичээлийн арга зүйн санаа боловсруулах:

Хичээлийн арга зүйн санаа гэдгийг, сурагчдын даалгаврын гүйцэтгэлд шинжилгээ хийх замаар сурагчдын эзэмшсэн мэдлэг, чадварын түвшинг илрүүлж улмаар сурагчдад тухай агуулгыг илүү сайн эзэмшүүлэх арга зүйн төлөвлөлт гэж ойлгож болно.

8 дугаар ангийн сурагчдаас авсан сорилын нэг даалгаврын сурагчдын гүйцэтгэлийн авч үзье.

(2018 он, Боловсролын хүрээлэн, “Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт түүнд нөлөөлж буй хүчин зүйл” судалгааны сурагчдын сорилын гүйцэтгэлийн үр дүнгээс)

Сурагчдын гүйцэтгэл:

	8 дугаар анги, Бүлэг сэдэв: Соёлын үнэт зүйл	Гүйцэтгэлийн хувь		Дундаж хувь
	Уран зургийн үнэ цэнийг тодорхойлж, зураг унших аргаар тайлбарласан	0		
Зохиомжийн онцлог, зургийн утга санааг тайлбарласан	15.3			
Зурагт дүрслэгдсэн зүйлсийг тоочин нэрлэсэн	72.4			
Огт тайлбарлаж чадаагүй	12.3			

Дүгнэлт: Даалгаврын сурагчдын дундаж гүйцэтгэлийг авч үзэхэд 35.5 хувьтай байна. Сурагчдын 85 орчим хувь нь зохиомжийн онцлогийг тодорхойлж, утга санааг баримтад тулгуурлан үр дүнтэй тайлбарлаж чадаагүй байгаа нь сурагчдын бүтээлч эрэлхийллийн арга барил, чадвар сул, агуулгын хэрэгжилт хангалтгүйг илтгэж байна.

Сурагчдын дүрслэх урлагийн бүтээлд идэвхтэй ажиглалт хийх, өөрсдийнхөөрөө ойлгож утга өгөх, холбогдох мэдээллийг сонгож цуглуулах, шинжилгээ хийх, уг уран бүтээлийг ойлгох, үнэлэлт өгөх замаар бүтээлч эрэлхийллийн арга барил, чадварыг дэмжсэн дараах арга зүйн санааг боловсруулсан.

Хичээлийн арга зүйн санаа

Суралцахуйн зорилт: 8.3а. Монголын дүрслэх урлагийн төлөөлөгчдийн бүтээлийг таньж тодорхойлох (1921 оноос өнөөг)

Суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэхдээ 1921 оноос одоог хүртэлх Монголын дүрслэх урлагийн төлөөлөгчдийн уран зургийн бүтээлээс сонгож тухайн уран зургийн бүтээлийг судалж, бүтээлч эрэлхийллийн замаар таньж тодорхойлоход чиглэнэ.

Хичээлийн сэдэв: О. Цэвэгжав “Азарганы ноцолдоон” уран зургийн бүтээл

1. Мэдрэх хүлээн авах үе шат: Уг үе шат нь уран зургийн бүтээлээр дамжуулан сурагчдын сонирхлыг төрүүлэх, мэдрэмж, төсөөллийг хөгжүүлэхэд чиглэнэ.

- Сурагчид уран зургийг харж ажиглах, өөрийнхөөрөө ойлгох, утга өгөх

Чиглүүлэх асуулт:

- Зураг дээр юу дүрсэлсэн болохыг тоочин нэрлэнэ үү?
- Уран бүтээлийн гол ба туслах дүрийг зургийн хавтгайн аль хэсэгт хэрхэн байрлуулсныг тодорхойлно уу?
- Зохиомжийн ямар арга ашигласан байна вэ?
- Зургийн өнгө зохицлыг өөрийн бодлоор тодорхойлон хэлнэ үү?
- Зургийн гол агуулга нь юу вэ? Хэрхэн илэрхийлсэн байна вэ?
- Тухайн зургийн талаарх өөрт төрсөн сэтгэгдлээ илэрхийлнэ үү?



2. Бүтээлч эрэл хайгуул хийх үе шат: Уг үе шатанд сурагчид тухайн зураг бүтээлийн талаар эрэл хайгуул хийж зураг бүтээлээс төрсөн анхны санаагаа хөгжүүлнэ.

- “Азарганы ноцолдоон” уран бүтээлийн талаар эрэл хайгуул хийх



Монгол Улсын Ардын зураач, Төрийн хошой шагналт,
XX зууны манлай зураач О.Цэвэгжав

Бүтээлчээр эрэл хайгуул хийх чиглэл:

- Уран зургийн нэр:
- Уран бүтээлчийн нэр:
- Уран бүтээл бүтээгдсэн он:
- Уран зургийн хэв маяг, ангилал:
- Энэ зураг хэр үнэ цэнэтэй вэ?
- Уран зургийн дүрслэлийг тоочин нэрлэнэ үү.
- Уран зургийн үйл явдал, утга санааг тайлбарлана уу.
- Уран бүтээлийн гол, агуулга илэрхийлэл юу вэ?
- Уран бүтээлчийн амьдрал, бүтээлийн талаар 3 сонирхолтой баримтыг бичнэ үү.
- Зургийг 3 үгээр илэрхийл: (түлхүүр үг)
- Зургийн талаар 3 үнэн, 1 худал өгүүлбэр бичнэ үү?

3. Ойлгох/ үнэлэх үе шат: Сурагчид тухайн уран зургийн үнэ цэнийг олж харах, өөрсдийн амьдрал дахь дүрслэх урлагийн холбоо хамаарлыг ойлгоход чиглэнэ.

“Азарганы ноцолдоон” уран бүтээлийн талаар хэлэлцэх



- Уран бүтээлийн эрэл хайгуул хийхийн өмнөх болон дараах төсөөллийг харьцуулах, мэдээлэл боловсруулах чиглэлээр бусадтайгаа санал бодлоо хуваалцах, нотолгоонд үндэслэн тайлбарлах
- Тухайн уран бүтээлийн онцлогийг хамтран тодорхойлох

ЕБС-ийн Дүрслэх урлаг хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хэрэглэх зөвлөмж боловсруулсан ажлын хэсэг:

С. Отгонтуяа	Боловсролын хүрээлэнгийн ЭША
Ч. Алтанчимэг	Зөвлөх багш, 20 дугаар сургуулийн багш
С. Цолмон	Зөвлөх багш, “Шинэ эхлэл” сургуулийн багш

Хөндлөнгийн шинжээч:

Д.Хөхөө	МУБИС-ийн ДУТС-ийн зөвлөх багш, доктор (Ph.D), дэд профессор
---------	--

Техникийн редактор:

Г. Дэлгэрмаа	Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн, доктор (Ph.D)
Ш.Сувдмаа	Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн, магистр

Хэвлэлийн эх бэлтгэсэн дизайнер:

С.Мөнхмаа	Интерпресс ХХК-ийн дизайнер, магистр
-----------	--------------------------------------

Цаасны хэмжээ: А4

Хэвлэлийн хуудас: 3.7 х.х

Дэлгэрэнгүй мэдээллийг:

www.eec.mn



Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6-р хороо,
Энхтайваны өргөн чөлөө, Оюуны ундраа группын байр,
Утас/Факс: 976-11 7011- 8486
И-мэйл: info@eec.mn Вэб: www.eec.mn